

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 11 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Г “Монголын компанийн засаглалын кодекс”-т 7
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалт, Дэлхийн банкны 2009 оны “Монгол улс дахь компанийн засаглалын үнэлгээний тайлан”-д тусгагдсан зөвлөмжийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т дор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “д”, “е”, 4 дэх заалтын “г” заалтууд, мөн зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “д”, “е”:

“д/ компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, зохион байгуулалт бүхий хувьцаа эзэмшигч нар нь хувь нийлүүлэгчдийн хуралд оролцон санал өгч, бодлогоо тодорхойлдог, бодитоор санал өгдөг, энэхүү байдлаа олон нийтэд болон бусад хувьцаа эзэмшигч нарт мэдээлдэг байх шаардлагатай. Эдгээр хувьцаа эзэмшигч нар нь компанийн засаглалыг сайжруулах, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр дэмжлэг үзүүлж ажилладаг байна;

е/ нэгдмэл сонирхолтой этгээдүүд, зохион байгуулалт бүхий хувьцаа эзэмшигч нарын ашиг сонирхлын нэгдмэл байдал, зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх бодлогыг тодорхойлж түүнийг олон нийтэд мэдээлдэг байна”;

2/ 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “г”:

“г/ компанийн чухал ач холбогдол бүхий мэдээ, мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд цаг алдалгүй мэдээлдэг байх, үүнийг цахим хуудаст байршуулах буюу жилийн үйл ажиллагааны тайланд тусгах.”;

3/ 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт:

“1.6.3. Компанийн ажилчид нь удирдлагын хууль зөрчсөн болон ёс зүйгүй, компанийн зорилгод үл нийцэх үйл ажиллагааны талаарх үнэн бодит мэдээллийг компанийн хяналтын зөвлөл, ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо, хувьцаа эзэмшигч,

харилцагчдад мэдээлдэг байх бөгөөд энэ үйлдлийнх нь төлөө түүнд удирдлагын зүгээс шийтгэл ногдуулдаггүй байна.”

2 дугаар зүйл. “Монголын компанийн засаглалын кодекс”-ын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын “ТУЗ-ийн бүрэн эрхийнхээ хүрээнд” гэсний дараа “дараахь” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалтын “б”-д “гүйцэтгэх удирдлага,” гэсний дараа “хэрэв гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлж байгаа бол” гэж, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “хууль ёсны” гэсний дараа “ашиг” гэж, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “а”-д “орон тооны ажилчинтай /компанийн” гэсний дараа “ТУЗ-ийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. “Монголын компанийн засаглалын кодекс”-ын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “хувьцаагаар” гэснийг “үнэт цаасаар” гэж, 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалтын “б”-д “мэдээлэл холбооны” гэснийг “мэдээлэл холбоо” гэж, 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалтын “бүрэн эрхээ бүрэн” гэснийг “бүрэн эрхээ” гэж, 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалтын “компанийн санхүүгийн байдал болон” гэснийг “компанийн санхүүгийн байдал,” гэж, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “б”-д “жагсаалтад байгаа, байхгүй байгаа талаарх” гэснийг “жагсаалтад байгаа эсэх талаарх” гэж, 3 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “а”-д “удирдлагын” гэснийг “удирдлага” гэж, 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын “б”-д “хооронд, том жижиг” гэснийг “хооронд болон” гэж, 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын “бүх гишүүдийн” гэснийг “ хувь нийлүүлэгчдийн” гэж, 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4 дахь заалтын “эрх бүхий албанд” гэснийг “эрх бүхий албан” гэж, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтын “бүхий л боломжит” гэснийг “бүхий л боломжтой” гэж, 5 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “г” заалтын “үнэн зөв байх, тодорхой, ойлгомжтой” гэснийг “үнэн зөв, тодорхой, ойлгомжтой байх” гэж, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “нийлэх, хуваах” гэснийг “нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах” гэж, 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалтын “шаардах үүрэгтэй” гэснийг “шаардах эрхтэй” гэж, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “нийтийн хүртээл болгохоос гадна” гэснийг “нийтэд мэдээлэхээс гадна” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. “Монголын компанийн засаглалын кодекс”-ын 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “дэргэдэх компанийн” гэснийг тус тус хассугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН